БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ

БАТЛАВ
ОРАКС ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.АМГАЛАН

ОРХОН АЙМАГ
ОРАКС ХХК
ТТО6064 4393732

**LKPB МАРКИЙН УУТАТ ШҮҮЛТҮҮРИЙН УУТ, УУТАНЦАР ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2023 оны 05-р сарын 26 өдөр Дугаар 2023/41 Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас “Оракс” ХХК-ийг төлөөлж захирал Б.Амгалан /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

1.1 Нийлүүлэгч нь “LKPB маркийн уутат шүүлтүүрийн уут, уутанцар” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу захиалагчийн агуулахад нийлүүлнэ.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 45 /дөчин тав/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

3.1 Энэ гэрээний нийт үнэ 160,180,020 /Нэг зуун жаран сая нэг зуун наян мянга хорь/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.
3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
3.3 Барааг хүлээлгэн өгсний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 4005012865 тоот дансанд шилжүүлнэ.

**Дөрөв.Талуудын хүлээх хариуцлага**

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа

төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.3 Нийлүүлэгч барааг Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан шүлт болон хүчилд тэсвэртэй зориулалтын утас, гал болон үрэлтэд тэсвэртэй материалаар техникийн тодорхойлолтод заагдсан загвар, хэмжээгээр нийлүүлнэ.

4.4 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах дахин үйлдвэрлэх зардлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.

4.5 Нийлүүлэгч нэг ширхэг уутыг үйлдвэрлэн авчирч хийц хэмжээний хувьд таарч байвал нийлүүлэх.

4.6 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172.

4.7 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Оракс” ХХК-ийн захирал Б.Амгалан хариуцан ажиллана. Утас- 99547378.

## Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон Улсын болон Монгол Улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.

5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэхээс хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.

5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.

5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 24 сарын баталгаа гаргана. Баталгаат хугацаанд нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан чанар, стандартын доголтой асуудлыг өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.

5.6 Барааг дараах баримт бичиг дагалдана. Үүнд:

- Барааны чанарын гэрчилгээ
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг
- Уутны материалын бүтэцийн техникийн тодорхойлолт, уутны материал, уут оёсон утас.

## Зургаа. Бараа хүлээн авах

6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад хүргэх ба захиалагч талаас бараа хүлээн авах комисс хүлээн авна.

6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

## Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцөлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.

7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд энэ тухайгаа нөгөө талдаа гэрээний хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

Уг мэдэгдэл нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаар баталгаажсан байна.

**Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан бараа нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

**Ес. Бусад нөхцөл**

9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.

9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.

9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.

9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.

9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.

9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.

9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАТТУЛГА

ЗУУХАН ЦЕХИЙН
ДАРГА Э.АРИУНБОЛД

ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТЭН Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :

ХАНГАМЖИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ш.ГАНТУЛГА

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ОРАКС ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Б.АМГАЛАН

ОРХОН АЙМАГ
ОРАКС
ХХК
ТТО6064 ☗ 4393732

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар*
*хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1*
*Утасны дугаар: 77111251*
РД: 6021646

*Хаяг:Орхон аймаг, Баян-өндөр сум, Баянцагаан баг*
*Үйлдвэрийн район*
*Утасны дугаар: 99547378*
*РД:4393732.*

Тоот гэрээний хавсралт

Нийлүүлэх  барааны жагсаалт

| № | Бараа материалын нэр | Тип марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | LKPB маркийн уутат шүүлтүүрийн уут, уутанцар | PPS+PTFE маркийн уут | ш | 750 | 213,573 | 160,180,020 |
| 2 | Бүгд үнэ /НӨАТ/-тай | | | | | **160,180,020** |

Барааны баталгаат хугацаа 24 сар байна.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Зуухан цехийн  дарга

Э.Ариунболд

Оракс ХХК-ийн

Захирал

Б.Амгалан

ОРХОН АЙМАГ ОРАКС ХХК ТТО6064 4393732

**LKPB маркийн уутан шүүлтүүр даавууны итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүн:**

**ШУТИС-ИЙН ХАРЪЯА ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН**
**THE RESEARCH AND DEVELOPMENT INSTITUTE OF LIGHT INDUSTRY, MUST**
**СОРИЛТЫН ТӨВИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**
**ACCREDITED LABORATORY OF TESTING CENTRE**

MNAS Accreditation system TL № 12-02

2023 он 05 сар 05 өдөр | **Дугаар (Test report No)** 537 | **Хуудас (Pages)** 1/1

| | | | |
|---|---|---|---|
| **Дээж ирүүлсэн байгууллага** /Requesting organization/ | **"ОРАКС" ХХК** | **Дээжийн дугаар** /Sample ID/ | 537 |
| **Дээжийн тодорхойлолт** /Sample definition/ | **Нэхээсгүй эд (Амгалан дулааны станц)** /Nonwoven material/ өнгө: шаргал color: buff | **Хүлээн авсан огноо** /Date received/ | 2023/05/04 |
| **Бүтээгдэхүүний стандарт** /Standard specification/ | | **Шинжилсэн огноо** /Date tested/ | 2023/05/05 |

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

| № | **Шинжилгээний аргын стандарт** /Test methods/ | **Үзүүлэлт** /Parameters/ | | **Хэмжих нэгж** /Units/ | **Шинжилгээний дүн** /Test results/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | ISO 15025:2003 | **Галд тэсвэрлэлт** /Fire flammability/ /10 секунд дол өгөхөд/ | **Шаталт үргэлжлэх хугацаа** /Continuing burning time/ | сек | **1,1** |
| | | | **Уугих хугацаа** /Smouldering/ | сек | **0,9** |
| 2 | ISO 9237 : 1995 | **Агаар нэвтрүүлэлт** /Air permeability/ D= 50mm<br>**агаарын зэлэхүүн** /air volume/<br>**агаарын хэмжээ** /air rate/ | | л/цаг/см$^2$<br>мм/с | **833,3**<br>**308,8** |
| 3 | MNS 2483:2008 | **1 м$^2$–ын жин** /Mass per 1 m$^2$/ | | г/м$^2$ /g/m$^2$/ | **628,1** |
| 4 | MNS 2483:2008 | **Зузаан** /thickness/ | | мм | **1,89** |
| 5 | MNS 1835-5:2007 | **Даац** /Strength/<br>**сууш** /in warp/<br>**хөндлөн** /in weft/ | | кг хүч<br>kg f | 114,7<br>167,7 |
| 6 | MNS 1835-5:2007 | **Суналт** /Extension/<br>**сууш** /in warp/<br>**хөндлөн** /in weft/ | | % | 30,4<br>37,2 |

**Тамга** /Stamp/

**Баталгаажуулсан:**
**Лабораторийн эрхлэгч**
/Approved by Head of Laboratory/
С. Саранцэцэг /signature/
С.Саранцэцэг

**Шинжилгээ гүйцэтгэсэн:**
/Tested by/ :
Шинжээч Л.Оюунчулуун
Шинжээч Х.Эрдэнэгэрэл
Шинжээч Э.Ганчимэг



INTERWOOLLABS
№.133

Сорилын дүн нь зөвхөн лабораторид ирүүлсэн дээжид хамаарна. Хүчинтэй хугацаа 60 хоног. Энэ сорилтын дүнг хуулбарлан ашиглахгүй ба зөвхөн баталгаажсан бүрэн эх байна.

The results contained in this report apply only to the sample submitted to the laboratory. Test report is valid for 60 days. This report must not be reproduced without the written authority of the laboratory.

ШУТИС, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн
Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-52,
Утас: 976-70003143, Факс: 976-11-343143, Шуудангийн хайрцаг 36/15

Research and development institute of light industry building-1, MUST, Chingis avenue-52,
Khan-Uul district, Ulaanbaatar, Mongolia, POBox 36/15,
Tel: 976-70003143, Fax: 976-11-343143, E-mail: rdili_mn@yahoo.com

# CERTIFICATE

SFCS-ISO9001/2022-062

This is to certify that

**ORACS LLC**

Site 1: Uildwer area, Bayantsagaan bag, Bayan-Undur soum, Orkhon aimag, Mongolia

Has implemented the Quality management system in accordance with the requirements of the standard

**ISO 9001:2015**

Scope of the Quality management system:

**Bag (sleeve) filter, Filter cloth, Big bag sewing**

Date of Initial certification: 2022

Date of issue: 20 Dec 2022
Valid until: 19 Dec 2025

Name of the certification body

SFCS LLC

G.UNDARIYA, CEO

IAF

MNAS

SFCS

www.sfcs.mn, SFCS LLC, Bayangol district, Ulaanbaatar, Mongolia

Бид харилцагчийнхаа итгэлийг олох, тэдний хэрэгцээ шаардлагад тохирсон чанар, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд **ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО** буюу **ISO 9001:2015, MNS ISO 9001:2016** стандартыг нэвтрүүлсэн.

# ГЭРЧИЛГЭЭ

SFCS-ISO9001/2022-062

**“ОРАКС” ХХК**

Хаяг 1: Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр, Баянцагаан баг, үйлдвэрийн район

Чанарын менежментийн тогтолцоог

**MNS ISO 9001:2016**

стандартын дагуу нэвтрүүлсэн тул олгов.

Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээ:

**Уутан (ханцуйт) шүүлтүүр, шүүлтүүрийн цамц, даацын шуудай оёдлын үйлдвэрлэл**

Анхны баталгаажуулалт: 2022 он

Олгосон огноо: 2022.12.20
Хүчинтэй огноо: 2025.12.19

Эс Эф Си Эс ХХК

Г.УНДАРЪЯА, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

www.sfcs.mn, Монгол улс, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот

SFCS

**ЭС ЭФ СИ ЭС ХХК-ИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН**

**ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 12-р сарын 20 ны өдөр        Дугаар 92/22        Улаанбаатар хот

*Гэрчилгээ олгох тухай*

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол Улсын хуулийн 15.2, 15.6 дахь заалт, Тохирлын үнэлгээ-Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17021-1:2020 стандарт, Компанийн Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын журмын 6.6 дахь заалт, Компанийн Баталгаажуулалтын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 20 ны өдрийн 091 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Оракс" ХХК-ын уутан шүүлтүүр, шүүлтүүрийн цамц, даацын шуудай оёдлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй Чанарын менежментийн тогтолцоо нь ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) стандартын шаардлагыг хангасан тул баталгаажуулалтын гэрчилгээг гурван жилийн хугацаатай олгосугай.
2. Баталгаажуулалтын гэрчилгээ, тэмдэг хэрэглэх тухай журмыг танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг баталгаажуулалт хариуцсан ажилтан (Н.Наранхүү)-т үүрэг болгосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА        Л.ТУНГАЛАГ

**Уутан шүүлтүүрт орж байгаа их бие материал, амсарт орж байгаа материал, ган цагариг, ган хадаас, хүчил шүлтэд тэсвэртэй оёдлын утас гээд бүгд стандарт шаардлага хангасан байх ёстой. Бид доор бүх материалын чанарын гэрчилгээг орууллаа.**

**Их биеийн чанарын гэрчилгээ:**

上海严牌滤布有限公司

SHANGHAI YANPAI FILTER CLOTH LIMITED COMPANY

品质证书

INSPECTION CERTIFCATE OF QUALITY

Name of product: Filter cloth of High temperature

Specification: PPS 200PP/RL1
Width: 440mm

Foundation: Specimen

Sample date: 2021-1-6

Sampling spot: Factory

Reporting date: 2021-1-17

| 检测项目 test item | 我方样品 Our sample |
|---|---|
| 材质 Material | PPS 聚苯硫醚 |
| 断裂强力 (经向/纬向 N/5×20cm) breaking strength warp/weft) (±5%) | 1247/1717 |
| 厚度 thickness mm (±5%) | 2.07 |
| 克重 weight per square meter g/m² (±5%) | 590 |
| 透气量 air input ... @200 Pa (±25%) | 210 |
| 后处理 Finish Treatment | 轧光 + 热定型 Calender & Heat |

**Уутны амсрын чанарын гэрчилгээ:**

浙江严牌过滤技术股份有限公司

YANPAI FILTRATION TECHNOLOGY CO., LTD.

品质证书

INSPECTION CERTIFCATE OF QUALITY

品名 Name of product: 袋口滤布 Filter cloth for bag mouth

规格 Specification: PPS 400g/m2 Width: 30mm

依据 Foundation: 标本样 Specimen

采样日期 Sample date 2021-1-11

采样地点 Sampling spot: 严牌工厂 YANPAI Factory

汇报日期 Reporting date: 2021-1-18

| 检测项目<br>test item | 随机取样<br>Random sampling |
|---|---|
| 材质 Material | PPS 聚苯硫醚 |
| 断裂强力 （经向/纵向 N /5×20cm）<br>breaking strength (warp/weft) (±5%) | 650/620 |
| 厚度 thickness mm (±5%) | 1.45 |
| 克重 weight per square meter g/m$^2$ (±5%) | 405 |
| 进气量 air input L/m$^2$·S @200 Pa (±25%) | 380 |
| 后处理 Finish Treatment | 热定型<br>Heat |

**Оёдлын утасны чанарын гэрчилгээ:**

# 上海严牌滤布有限公司

## SHANGHAI YANPAI FILTER CLOTH LIMITED COMPANY

## 品质证书

## INSPECTION CERTIFCATE OF QUALITY

Name of product：Swing thread

Specification：PTFE

Foundation：Specimen

Sample date：2021-1-9

Sampling spot：Factory

Reporting date：2021-1-17

| 检测项目<br>test item | 我方样品<br>Our sample |
|---|---|
| 材质 Material | PTFE 聚四氟乙烯 |
| 拉伸率 (%)<br>Elongation (%) (±5%) | 2.93 |
| 断裂强力 (cN)<br>Breaking strength (cN) (±5%) | 77.36 |
| 断裂时间 (S)<br>Breaking Time (S) (±5%) | 2.19 |
| 断裂功 (cN.mm)<br>Work of fracture (cN.mm) (±5%) | 20259.83 |
| 断裂强度 (cN/detx)<br>Fracture strength (cN/detx) (±5%) | 3.49 |

**Ган цагаригны чанарын гэрчилгээ:**

# 浙江严牌过滤技术股份有限公司
# YANPAI FILTRATION TECHNOLOGY CO., LTD.

## 品质证书
## INSPECTION CERTIFCATE OF QUALITY

品名 Name of product: 不锈钢带 Stainless steel strip

规格 Specification: PPS 200PP/RL1 Width: 30mm

依据 Foundation: 标准样 Specimen

采样日期 Sample date: 2021-1-10

采样地点 Sampling spot: 严牌工厂 YANPAI Factory

汇报日期 Reporting date: 2021-1-17

| 检测项目<br>test item | 随机取样<br>Random sampling |
|---|---|
| 材质 Material | STELL 不锈钢 |
| 宽度 Width | 30 mm |

**Ган цагариг хадах ган хадаасны чанарын гэрчилгээ:**

# 浙江严牌过滤技术股份有限公司
# YANPAI FILTRATION TECHNOLOGY CO., LTD.

## 品质证书
## INSPECTION CERTIFCATE OF QUALITY

品名 Name of product：铆钉 Rivet

规格 Specification：stainless steel

依据 Foundation：标本样 Specimen

采样日期 Sample date：2021-1-10

采样地点 Sampling spot：严牌工厂 YANPAI Factory

汇报日期 Reporting date：2021-1-17

| 检测项目<br>test item | 随机取样<br>Random sampling |
|---|---|
| 材质 Material | STELL 不锈钢 |

**Yanpai компани шүүлтүүр даавууны чанарын баталгаа:**

## Quality commitment of filter bag

PPS+PTFE filter bag produced by our company in the use of instant temperature ≤220 degrees Celsius, the filter wind speed is not greater than 0.8m/min conditions under the use of quality guarantee for two years.

YANPAI FILTRATION TECHNOLOGY CO., LTD.

**Англи хэлнээс орчуулав.**

Шүүлтүүрийн уутны чанарын баталгаа

Манай компанийн үйлдвэрлэсэн PS+PTFE шүүлтүүрийн уутыг 220 хэм хүртэлх температурт, шүүлтүүрийн салхи, агаарын хурд нь 0.8м/мин-ээс ихгүй нөхцөлд ашиглах бөгөөд чанарын хоёр жилийн баталгаатай.

"ЯНПАЙ ФИЛТРЕЙШН ТЕХНОЛОГИ ХХК

"Ханжаргалант Амар" Баталгаат орчуулгын товчоонд орчуулж баталгаажуулав.
Утас: (976) 99365624, Email: erdenet/orchuulga@gmail.com

Ora Consulting Service

# ОРАКС ХХК

ОРА КОНСАЛТИНГ СЕРВИС

## *CERTIFICATE OF QUALITY /ЧАНАРЫН ГЭРЧИЛГЭЭ*

**Product made in/Үйлдвэрлэсэн:** "ОРАКС" ХХК, Эрдэнэт хот

**Customer/Худалдан авагч** "АМГАЛАН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК

**Purchare Order Number /Захиалгын дугаар** **№ АДС/202301009**

**Descripton:** **Bag filter**, Dust collector Ф130x8150mm

**Material : PPS+PTFE**

**Breaking strength(warp/weft) N/5x20cm (+/-5%) :** **1247/1717**

**Thickness/зузаан, mm** (+/-5%): 2.07

Weight per square metrs g/m2(+/-5%) : 590

**Air input/агаар нэвтрүүлэлт L/m2*S @200Pa(+/-25%):** **210**

**Temperature restance/Ашиглах температур** **220C**

Test Report of Yanpai filter cloth LLC, China

ОРХОН АЙМАГ ОРАКС ХХК

Authorized /Гарын үсэг:____ / 2023.05.03 /

Director B.Amgalan / Захирал Б.Амгалан Date / Дата

**Үйлдвэрлэгчийн хаяг:**

**Монгол улс, Орхон аймаг, Эрдэнэт хот , "Оракс" ХХК**

**Утас: 99547378** **email: oracs2013@yahoo.com**